

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Түнэл-Илч” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 "Түнэл-Илч" ХХК ба түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	8
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
4. Аудитын тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны мэдээлэл	11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
5.1 Төлбөрийн акт	12
5.2 Албан шаардлага.....	12
5.3 Зөвлөмж	12
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлчилгээний газар



“ТҮНЭЛ-ИЛЧ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ж.БАДРАЛ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.06 № 01/261
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Түнэл-Илч” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Түнэл-Илч” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болсон байна.

Аудитын гол асуудал

“Түнэл-Илч” ХХК нь тайлант онд Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/70 тоот тушаал, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/92 захирамжаар нийт 70.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Түнэл-Илч” ХХК нь 2022 оны зорилтот түвшний биелэлт 99 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 03 сарын 15 өдөр

№ 45/АД2210439/ХӨА-2023/06
1НА-СТА-1НА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түнэл сумын "Түнэл Илч" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Байгууллагын төсвөөс 957,500 (Есөн зуун тавин долоон мянга таван зуун) төгрөгөөр бэлэг, шампанск худалдан авч үр ашиггүй зардал гаргасан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-ыг хориглоно, 15.1.7. "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-ыг хориглоно гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр бэлэг, шампанск худалдан авсан 957,500 (Есөн зуун тавин долоон мянга таван зуун) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Түнэл сумын "Түнэл Илч" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Бадрал нягтлан бодогч Б.Лхагва-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0	0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	561,196.53	3,430,500.73
1.1.2	Дансны авлага	283,492.00	1,671,250.00
1.1.6	Бараа материал	55,750,791.21	46,546,575.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	56,595,479.74	51,648,325.73
1.2.1	Үндсэн хөрөнгө	494,544,663.84	527,242,053.12
1.2.2	Биет бус хөрөнгө	23,358,500.00	23,358,500.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	517,903,163.84	550,600,553.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	574,498,643.58	602,248,878.85
2.1.1.1	Дансны өглөг	25,026,348.00	73,360.00
2.1.1.3	Татварын өр	0	1,181,119.75
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	25,026,348.01	1,254,479.74
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0	21,811,769.83
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0	21,811,769.83
2.2	Өр төлбөрийн нийт дүн	25,026,348.01	23,066,249.57
2.3.1	Өмч: - төрийн	178,862,641.08	178,862,641.08
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	174,175,791.10	174,175,791.10
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	208,969,623.00	279,059,624.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-12,535,759.61	-52,915,426.90
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	549,472,295.57	579,182,629.28
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	574,498,643.58	602,248,878.85

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	287,527,506.73	326,777,629.35
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	190,354,666.18	317,946,715.82
3	Нийт ашиг (алдагдал)	97,172,840.55	8,830,913.53
10	Ерөнхий ба удирдлагын зардал	34,782,700.61	27,115,810.99
12	Бусад зардал	12,299.18	283,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	62,377,840.76	(18,567,897.46)
19	Орлогын татварын зардал	6,237,784.02	21,811,769.83
20	Татварын дараах ашиг (алдагдал)	56,140,056.74	(40,379,667.29)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	56,140,056.74	(40,379,667.29)
24	Орлогын нийт дүн	56,140,056.74	(40,379,667.29)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	178,862,641.08	174,175,791.10	23,870,000.00	43,420,343.96	420,328,776.14
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0	0.00

Тайлант цэвэр (алдагдал) үеийн ашиг	0	0	0	-55,956,103.57	-55,956,103.57
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	185,099,623.00	0	185,099,623.00
2022 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	178,862,641.08	174,175,791.10	208,969,623.00	-12,535,759.61	549,472,295.57
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0	0.00
Тайлант цэвэр (алдагдал) үеийн ашиг	0	0	0	-40,379,667.29	-40,379,667.29
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0.00
Өмчид гарсан өөрчлөлт		0	70,090,001.00		70,090,001.00
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	178,862,641.08	174,175,791.10	279,059,624.00	-52,915,426.90	579,182,629.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	317,398,968.40	354,076,255.88
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	307,440,228.40	351,324,346.88
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0	112,599.00
	Бусад мөнгөн орлого	9,958,740.00	2,639,310.00
1.2	Мөнгөн зарлага (-)	277,139,738.86	349,967,641.68
	Ажиллагчдад төлсөн	82,193,163.43	113,068,511.81
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	25,630,420.26	32,342,472.19
	Бараа материал худалдан авахад төлсөн	91,824,350.00	103,606,788.00
	Ашиглалтын зардалд төлсөн	24,915,038.09	26,997,268.05
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,804,055.00	29,439,040.00
	Татварын байгууллагад төлсөн	31,635,712.90	32,875,041.63
	Даатгалын төлбөрт төлсөн	0	3,223,300.00
	Бусад мөнгөн зарлага	3,136,999.18	9,654,530.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,259,229.54	4,108,614.20
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	42,500,000.00	0
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	42,500,000.00	0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-42,500,000.00	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	30,183,197.27	2,869,304.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,999,311.98	561,196.53
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,816,114.70	3,430,500.73

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Орлогын ангилал	2022 оны төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
1	Халаалтын орлого	309,974,272	322,173,930	(12,199,658)	103%
2	Халуун усны орлого	9,600,000	1,430,000	(8,170,000)	0,14%
3	Бохир ус соруулсны орлого	8,400,000	1,161,100	(7,238,900)	0,13%
4	Хогны орлого	6,000,000	2,012,599	(3,987,401)	0,33%
	Нийт орлогын дүн	334,334,272	326,777,629.35	98%	94.18%
	НИЙТ ЗАРДАЛ			-	0.00%
1	Цалин	107,300,898.00	102,633,489.00	4,667,409	95,65%
2	НДШ	17,368,230.00	19,299,964.00	(1,931,734)	111%
3	Нүүрс	53,460,000.00	62,528,988.00	(9,068,988)	117%
4	Тээврийн зардал	23,300,000.00	23,300,000.00	-	100%
5	Шатахууны зардал	7,608,210.00	13,839,040.00	(6,230,830)	189%
6	Гэрэл цахилгаан зардал	30,290,852.00	26,997,268.05	3,293,583.95	89%
7	Бичиг хэрэг	640,000.00	660,100.00	(20,100)	103%
8	ТУЗ	10,000,000.00	12,596,216.00	(2,596,216)	126%
9	Хөдөлмөр хамгаалал	8,015,200.00	11,335,620.00	(3,320,420)	141%
10	Томилолт	1,528,000.00	38,000.00	1,490,000	0,02%
11	Холбооны зардал	300,000.00	25,000.00	275,000	0,08%
12	Засвар үйлчилгээний зардал	20,414,500.00	19,710,180.00	704,320	96%
13	Тэтгэмж урамшуулал	14,683,752.00	6,963,816.00	7,719,936	47%
14	Нохой устгалын зардал	1,500,000.00	2,380,000.00	(880,000)	158%
15	Төлбөр хураамж	4,311,301.00	5,310,356.21	(999,055.21)	123%
16	Төлбөр хураамж	500,000.00	481,800.00	18,200	96%
17	Үл хөдлөх хөрөнгийн татвар	1,476,480.00	1,476,480.00	-	100%
18	ЭХХЗ-ийн хураамж	1,171,821.00	1,171,821.00	-	100%
19	Зам ашигласны татвар	20,000.00	20,000.00	-	100%
20	Авто тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00	-	100%
21	Агаарын бохирдлын татвар	9,500.00	9,500.00	-	100%
22	Газрын татвар	56,264.00	56,264.00	-	100%
23	ААНОАТатвар	691,991.21	691,991.21	-	100%
24	Мод тарих	212,500.00	212,500	-	100%
25	Элэгдлийн зардал	1,321,519.00			
26	Хөрөнгө оруулалт	16,650,000.00		16,650,000	
27	Даатгал	3,223,300.00	3,223,300.00	-	100%
28	Хогны хураамж	5,900,000.00	5,900,000.00	-	100%
29	Санхүүгийн тооцоолох групп	286,000.00	286,000.00	-	100%
30	НИЙТ	318,692,462.00	317,027,337.26	1,665,124,74	99%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Түнэл-Илч” ХХК ба түүний үйл ажиллагаа

Тус компани нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймаг, Түнэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлнэ.

Компани нь нийт 19 ажилтантай ба Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан үйлдвэрлэх, түгээх, борлуулах
- Ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Компани нь 2011 оноос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 82 дүгээр тогтоолоор "Түнэл-Илч" ХХК болон өөрчлөгдсөн байна.

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

Түнэл сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 2021 оны 05 сарын 11-ний өдрийн 33 дугаар тогтоолоор компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

Компанийн гүйцэтгэх захирлыг Хөвсгөл аймгийн Түнэл сумын "Түнэл-Илч" ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны 02 тоот тогтоолоор томилсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Түнэл-Илч" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Түнэл-Илч" ХХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр захирлын тушаалаар баталсан бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 1-ний дотор шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Компани нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагдах аргаар бүртгэж тайлагнадаг.

Санхүүгийн бүртгэлийн программаар Leader программыг ашигладаг ба үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй эдийн засгийн орчинд ашиглагдаж байгаа бусад системтэй уялдаагүй мэдээлэл солилцоход хүндрэлтэй, систем дотроо цалин хөлс, урьд оны үлдэгдэл зэрэг мэдээллийг дутуу татаж санхүүгийн тайланг алдаатай илэрхийлж, дахин дахин тооцоолохтой холбогдож нягтлан бодогчид болон бидний ажилд хүндрэл учруулж байна.

Тухайлбал: Өртөг, зардлын хуваарилалтыг бүрэн хийх боломжгүй, гар ажиллагаа ихтэй байна.

"Түнэл-Илч" ХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27.8 сая төгрөгөөр буюу 4.8 хувиар өсөж 602.3 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.6	3.4	2.8
Авлага	0.3	1.7	1.4
Бараа материал	55.7	46.5	(9.2)
Үндсэн хөрөнгө	494.5	527.2	32.7
Биет бус хөрөнгө	23.4	23.4	-
Нийт хөрөнгө	574.5	602.3	27.8
Өр төлбөр	25.0	23.1	(1.9)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	549.5	579.2	29.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	574.5	602.3	27.8

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 3.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна. Дансны авлагын үлдэгдэл 1.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, өр төлбөр 23.1 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46.5 сая төгрөг болж өмнөх оноос 9.2 сая төгрөгөөр буурсан нь нүүрсний үнэ ханш нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хөдөлгөөн дараах шалтгаанаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/70 тоот тушаалаар орон нутгийн төсвөөс 39.9 сая төгрөгийн хогны машин шинээр өгсөн, мөн Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/92 захирамжаар 12.0 сая төгрөгийн Зи-930 авто ачигч, 2.0 сая төгрөгийн хогны машин, 11.6 сая төгрөгийн бохирын машин, 4.6 сая төгрөгийн гал унтраах чиргүүл балансаас шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 119 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралаар "Түнэл-Илч" ХХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 03 дүгээр тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 334.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 331.6 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 2.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 23-ны 04 дүгээр тогтоолоор "Түнэл-Илч" ХХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг нийт зардлыг 3.7 сая төгрөгөөр бууруулж 327.9 сая төгрөг байхаар тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 326.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 298.5 сая төгрөгийн зардал гарган, 1.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 326.8 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 7.5 сая төгрөг буюу 2.3 хувиар бага байна. Үүнд иргэдээс бохир ус, хогны орлого ороогүйгээс голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 317.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1.7 сая төгрөг буюу 0.5 хувиар бага зарцуулсан гүйцэтгэлтэй байна. Тайлант онд 40.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба түүнд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Тайланд онд 1тн нүүрсний ханш 9,400 төгрөгөөр өссөн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

дд	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл					
	Халаалтын орлого /НӨАТ-тай дүн/	316.2	310.0	322.2	12.2	103.0
1	Цэвэр усны орлого	0	0	0	0	0
	Халуун ус		9.6	1.4	(8.2)	0.14
	Бохир ус соруулсны орлого		8.4	1.2	(7.2)	0.13
	Хогны орлого		6.0	2.0	(4.0)	0.33
2	НИЙТ ОРЛОГО	316.2	334.3	326.8	(7.5)	94.1
3	НИЙТ ЗАРДАЛ	372.6	318.7	317.0	(1.7)	99.0
4	Татварын өмнөх ашиг	-56.4	2.7	(0.6)	(3.3)	(22.0)
5	Цэвэр ашиг /алдагдал/	-56.4	2.0	(1.4)	(3.4)	(70.0)
8	Нийт ажиллагсдын тоо	15	15	19		
9	Нийт цалингийн сан	99.1	107.3	102.6	(4.7)	95.6
13	Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал	1.8	1.1	1.0	(0.1)	90.0
15	НИЙТ АВЛАГА	0.3	0.3	1.7	1.4	566.6
16	НИЙТ ӨГЛӨГ	24.9	25.0	1.3	(23.7)	5.2
	Үүнээс: Богино хугацаат	24.9	25.0	1.3	(23.7)	5.2

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Түнэл-Илч" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлын данстай холбоотой, гэрээ хэлцлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

"Түнэл-Илч" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 5.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 325.8 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 112.2 сая төгрөгийн 3 залруулга хийж, 213.6 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	213.6	4	213.6	100
Нийт дүн	4	213.6	4	213.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 45.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн хөрөнгөөр 1.0 сая төгрөгийн бэлэг бэлтгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтгүйгээр 12.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хийж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 заалт зөрчсөн бөгөөд "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах.

2. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 1.2 сая төгрөгийн өглөг үүсгэсэн нь төсвийн тухай хуулийн 6.4.8 заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг барагдуулж, цаашид өглөг үүсгэхгүй ажиллах.

3. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 1.7 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь төсвийн тухай хуулийн 6.4.8 заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулж, цаашид авлага үүсгэхгүй ажиллах.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5, 6.1.1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна. "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулж ажиллах.

5. Бусад асуудалтай холбоотой

Илрүүлэлт: Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа орлого зардлыг бодитой төлөвлөж хэрэгжүүлээгүйгээс алдагдалтай ажиллах үндэс бий болсон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3 "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа орлого зардлыг бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх.

6. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: "Түнэл-Илч" ХХК нь 2018 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ашиглаж байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад журам, тушаалуудад гарсан өөрчлөлт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төсвийн хөрөнгөөр бэлэг бэлдсэн	1	1.0	1	1.0									
Анхан шатны баримт дутуу гүйлгээ хийсэн	1	12.3					1	12.3					
Өр төлбөр үүсгэсэн	1	1.2					1	1.2					
Авлага үүсгэсэн	1	1.7					1	1.7					
Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа орлого зардлыг бодитой төлөвлөж хэрэгжүүлээгүйг	1	0					1	0					
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлага хангаагүй	1	0					1	0					
Нийт	5	15.2	1	1.0			5	15.2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг бүртгээгүй	1	30.1					1	30.1

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

